

## ӨНӨӨГИЙН МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

*Л.Бэгзжав\**

Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор хоёр талын Гадаад харилцааны Яамны сайд нар 2011 оны 3-р сард Улаанбаатар хотноо тохиролцож, дээд түвшинд тодорхой баримт бичиг гаргахаар бэлтгэж байна. Хэдийгээр энэ асуудлаар хоёр тал урьдчилан тохирсон ч ийм харилцаа тогтооход, тогтоосоны дараа ч хоёр талын харилцаанд нөлөөлөх зарим нэг асуудал оршсоор байна. Оршиж буй асуудлыг эс анхаарваас Монгол, Хятадын харилцаа гүнзгийрүүлэн хөгжихөд гэнэтийн нөхцөл байдал, сөрөг үр дагавар үүсэх талтай.

Монгол, Хятадын харилцаа албан бус түвшинд, жирийн иргэд хоорондын үл итгэлцэх сэтгэл зүй амь бөхтэй оршсоор байна. Хоёр орны албан ёсны харилцаа дээд түвшинд сайн байгаа боловч энэ нь зарим талаар өнгөц, харагдах байдал юм. Түүхэн учир шалтгаан, уламжлал, нийгмийн байдал, аж амьдралын хэв маягийн ялгаа зэрэг хүчин зүйлээс улбаалан хоёр орны хооронд үл ойлголцох, санал нэгдээгүй, өөр өөр байр суурьтай асуудал байсаар байна.

**Улс төрийн талаар:** Монгол Улс ардчилалд орсоноос нааш хэт барууны чиг баримтлалыг баримталж олон улсын төвшинд АНУ-ыг дагах, өрнөдийн бодлого шахалтанд автах хандлагатай байна. Иракт цэрэг оруулсан, энхийг сахиулах нэрээр НАТО-той идэвхтэй түншилж байгаа нь Хятадын геополитик, эрх ашиг, сонирхолтой зөрчилдөж байна.

**Эдийн засгийн хувьд:** Хятадын тал Монголын эдийн засаг Хятадын тусламж дэмжлэггүйгээр хөгжихөд бэрх, уул уурхайн эд баялагаа Хятадаар дамжуулахгүйгээр гадагш гаргаж чадахгүй гэсэн хааж боох дарамт үзүүлэх хандлагатай байна. Монгол Улс Хятадын хөрөнгө оруулалтыг төдий л дэмжихгүй байгаа нь Монголын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөтэй гэж улс төрийн зарим хүчин үзэж байгаатай холбоотой. Таван толгой, Оюу толгой, нарийн царигтай төмөр зам тавих зэрэг бодлогын асуудлаар хоёр орны эдийн засгийн байр суурь, ашиг сонирхол нэлээд зөрүүтэй байна.

**Цэрэг батлан хамгаалах тухайд:** Монгол Улс НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд оролцож, Ази-Номхон далайн бүс нутгийн талаархи Америкийн стратегийн бодлогыг дэмжиж байна. Монголд учруулах “Хятадын аюул занал” хэвээр байгааг судлаачид, улс төрийн бодлоготонууд тэмдэглэсээр байна. Ийм учраас НАТО, АНУ, ХБНГУ-тай түншилж тэдний хөрөнгө хүчээр батлан хамгаалах салбартаа шинэчлэл хийж байгааг Хятад улс болгоомжлох, сэжиглэх байр сууринаас хандаж байна.

**Хүмүүнлэг, соёлын салбарт:** Хоёр орны хооронд түүхийн асуудлаар маргаан, зөрчил их байна. Үндэстний түүх, соёлын өвийн талаар

\* Л.Бэгзжав - ОУСХ-ийн Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор

байр суурь зөрөөтэй байгаа нь хоёр ард түмний итгэлцэлийн асуудал түүхэн улбаатайг харуулж байна.

Энэ бүхнийг тодорхой яривал:

1. Улс төрийн яриа хэлцэл, гэрээ хэлэлцээрийн агуулга, хамрах хүрээ, хэрэгжиж буй байдал, ач холбогдол бага байна. Жишээлбэл: Хоёр орны засгийн газар хоорондын боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай 1998 оны хэлэлцээр, түүний хугацааг сунгасан тухай 2010 оны 6-р сарын хэлэлцээрийн хэрэгжилтийг дурдаж болох юм. Энэ нь хоёр орны эрдмийн зэргийн тогтолцоо өөр, суралцах хугацаа адилгүй зэргээс шалтгаалж, Хятадад магистр хамгаалбал Монголд доктор (Ph.D) гэж тооцох, эсвэл доктор (Ph.D) хамгаалбал шинжлэх ухааны доктор (Sc.D) гэж тооцох, Хятадаас Монголд магистр цолтой хүн докторын зэрэг хамгаалбал магистр гэж тооцох, дээр дурдсан хэлэлцээр байгуулагдахаас өмнө хоёр талд хамгаалсан эрдмийн зэргийг хүчингүйд тооцох зэрэг байдал ажиглагдаж байна.

2. Хоёр орны Засгийн газрын хэлэлцээрийн дагуу жил бүр БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр бакалавр, магистр, докторын сургалтанд хамрагдах хүмүүсийн сонгон шалгаруулалт ил тод биш байгаатай холбогдуулан Монголд арын хаалга, хээл хахуултай холбон энэ асуудлыг улс төржүүлэх яриа их гарч байгаа нь хоёр талын харилцаанд сэжиглэлтэй хандах сэтгэгдэл төрүүлж байна. Ялангуяа Монголын УИХ, Засгийн газрын байгууллагуудын албан тушаалтаны хүүхэд тэтгэлэгт сургалтанд ихээр хамрагдаж байгаа нь ийм яриа гаргахад хүргэж байна.

3. Монголд, Хятадын түүхийн асуудлаар хоёр тал өөр өөр байр суурьтай, энэ талаархи хоёр талын үзэл бодол, санал зөрөлдөөн хойшдоо ч байх юм. Энэ асуудлыг хоёр орны удирдагчид, албан ёсны хүрээнд нэг ч удаа хөндөөгүй учир, хоёр талын эрдэмтэд, судлаачид, ард иргэдийн түүхийн ойлголт, санал зөрөлдөөн улам даамжирсаар байна. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, түүхийг үзэх монгол сэтгэлгээ, байр суурь өөрчлөгдөхгүй нь тодорхой бөгөөд хоёр талын түүхийн маргаантай асуудлыг хэрхэн зохицуулах, ямар чиг шугам баримтлах нь тодорхойгүй, маргаантай байгаагаас хоёр орны харилцаанд, ялангуяа улс төрийн харилцаанд хэзээ нэг цагт сөрөг нөлөөлөл гарах магадлал өндөр юм.

4. Үүнтэй холбогдуулан Монголд “Хятадын аюул” байгаа гэсэн байнгын хардалт байдаг. Монгол Улсыг Хятад улс алсдаа Тайваний нэг адил нэгтгэх бодлого явуулж, эдийн засаг, соёл, үзэл суртал зэрэг бүхий л салбарт “хараат байлгах”, далд санаа, стратеги бодлоготой байдаг гэдэгт нэлээдгүй монгол хүн итгэдэг. Иймээс ч Хятадад хандах монголчуудын хандлагад өөрчлөлт гардаггүй нь үүнтэй холбоотой.

5. Монголд “үндэстэний асуудал”-д эмзэг хандах байдал илэрч байна. Өвөр монголчуудыг хятадаас дор санаатай гэх яриа сүүлийн үед их гарч, өвөр монголчуудыг хужаа, хятад хүн гэж доорд үзэх явдал байсаар байна. Монголын хүн амын цөөнх болох казакуудын бие даах, Казакстан болон Хятадын казак, уйгаруудтай ойртох, ёс заншил, мусульман шашны өвөрмөц

байдлаа хадгалах хандлагад дургүйцэх, үл ойлголцох, байдал газар авч байна. Энэ бүхэн нь үндэстний асуудал хоёр орны харилцаанд ч “эмзэг” нөлөөлөх нэг асуудал болно.

6. Шашны асуудал буюу Далай ламын талаархи байр суурь нэн зөрөөтэй байсаар байна. Монголчууд эрх чөлөөний тухай, шашин шүтлэг чөлөөтэй байх талаар их ярьж, Далай ламтай харилцах, IX Богдыг Монголд тодруулах монголын иргэн болгох зэрэг асуудлын талаархи байр суурь нь хятадтай цаг ямагт зөрөлдөж байдаг. Шашны асуудалд монголчууд хувийн сүсэг бишрэлийн үүднээс ханддаг ба үүний цаана “том” улс төр, улс хоорондын санал зөрөлдөөн, геополитик оршиж байгааг төдий л анзаардаггүй. Төвдийн асуудлыг улс төрийн асуудал гэхээсээ шашны зан үйлтэй холбож ойлгох нь элбэг. Тиймээс ч Дармасалад монголчууд чөлөөтэй зорчиж, хүссэн хүн бүхэн шахам Далай ламтай уулзаж байна. Төвд лам нар монголд чөлөөтэй амьдарч байна. Хэдий олон тоотой биш боловч монгол дахь төвдийн цагаачлал, шилжин суурьших асуудал цаашид хурц асуудал үүсгэж болох юм.

7. Хятадын цагаач иргэдийн асуудал Монгол, Хятадын харилцаанд хөндүүр нэг сэдэв юм. Монголын улс төрд эрлийз, цагаач гэдэг үг их хүчтэй эмзэглэл төрүүлдэг ба цагаачдын асуудлын цаана хөрөнгө мөнгө, авилгал, улс төрийн эрх мэдэл, эдийн засгийн луйврын асуудал ямагт яригддаг. Монголын улс төрд эрлийз, цагаач гаралтай хүмүүс олноор гарч ирж байгаад дургүйцсан “Даяар Монгол”, “Хөх Монгол” зэрэг үндсэрхэг үзэлт залуучуудын урсгал хөдөлгөөн байнга гарч, үл итгэлцэлийг гүнзгийрүүлэхэд сөрөг нөлөө, сөрөг үр дагавар авчирч байна. Хятадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хооронд байнга маргаан, хэрүүл, зодоон зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл гарсаар байна.

8. Монгол Улс Тайванийг Хятадын газар нутгийн салшгүй нэг хэсэг “Нэг улс-хоёр нийгмийн байгуулалтай гэдгийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Гэвч хэрэг дээрээ Монгол Улс жижиг орны хувьд Тайваний эдийн засаг, хөрөнгө оруулалтын дэмжлэг авахыг чармайж байна. Тайваний талаар нам бүлэг, улс төрийн хүчнүүд тус тусдаа бие даасан бодлого явуулж хэрэг дээрээ Тайванийг дэмжих, улмаар АНУ-ын Тайваний талаархи бодлого эрх ашгийг дэмжиж байгаа нь Хятадын бодлоготой зөрчилдөж байна. Тайваний талаархи Хятад, Америкийн стратеги, байр суурь зөрүүтэй нөхцөлд Монгол Улс Тайваний төлөөлөгчийн газрыг Монголд нээн ажиллуулж байгаад Хятадын зүгээс нааштай хандахгүй байна. Тайваний талаас ч идэвхтэй ажиллаж тэтгэлэгт сургалт, хүмүүнлэгийн тусламж үзүүлсээр байна. Монголд Тайванийг Хятадаас тусгаар улс гэж үзэх ойлголт жирийн иргэдийн дунд нийтлэг байна.

Дурьдсан бүх асуудлыг ултай нарийвчлан судалж, хоёр талын зохих байгууллагууд харилцан зохицож, хууль эрх зүйн үүднээс зөв бодлого баримтлахгүй бол эндээс үүдэн гарах хор уршиг хоёр талын харилцаанд саад болсоор байх болно.